

## ТАНИЛЦУУЛГА

### Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн талаар

Монголчууд эртнээс нохойг хашаа хороо, мал сүргээ мануулах зорилгоор тэжээж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд хотжих үйл явцын үр дүнд нохой, муур болон бусад гэрийн тэжээвэр амьтныг тэжээх, үржүүлэх явдал нэмэгдсээр байна. Үүнтэй зэрэгцэн гэрийн тэжээвэр амьтныг хяналтгүйгээр үржүүлж, улмаар эзэнгүй амьтны тоо толгой нэмэгдэх, гэрийн тэжээвэр амьтан тэжээхдээ хариуцлагагүй хандах, бусдын эрхийг зөрчих, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх, амьтны эсрэг хүчирхийлэл үйлдэх гэх мэт олон асуудлууд нийгэмд гарч байна.

Монгол Улсад мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг Амьтны тухай хуулиар, мал, тэжээвэр амьтан (гахай, тахиа зэрэг ашиг шимийг нь ашиглахаар үржүүлж байгаа амьтан), зэрлэг амьтны эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Харин гэрийн тэжээвэр амьтан буюу нохой, муур, тэдгээртэй адилтгах бусад амьтантай холбогдох асуудал одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор зохицуулагдаагүй үлджээ.

Иймд гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцааг зохицуулахаар Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг 9 бүлэг, 52 зүйлтэйгээр боловсрууллаа. Хуулийн төслийн зорилго нь гэрийн тэжээвэр амьтдын асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэрийн тэжээвэр амьтдаас үүдэн нийгэмд гарч буй сөрөг үр дагавар, бусдын эрхийг зөрчих явдлыг бууруулах, нохой, муур үржүүлэх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх, эзэнгүй амьтдын тоо толгой, гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийг бууруулахад оршино.

**Нэгдүгээр бүлэг** буюу нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилт, гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчмыг тус тус тусгасан.

Хуулийн зорилт нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гэрийн тэжээвэр амьтныг бүртгэх, асран хамгаалах, түр харах, үржүүлэх, хүчирхийллээс хамгаалах, эзэнгүй амьтны тоо толгойг бууруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд “гэрийн тэжээвэр амьтан” гэдгийг нохой, муур болон ашиг шимийг нь ашиглахаас бусад зорилгоор гэршүүлсэн, хүнтэй хамт амьдрах боломжтой Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.3-т зааснаас бусад амьтныг ойлгохоор тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-т "тэжээвэр

амьтан" гэж ашиг шимийг нь ашиглах болон бусад хэрэгцээнд зориулан гэршүүлэн үржүүлж байгаа амьтныг ойлгоно гэсэн тодорхойлолтоос гэрийн тэжээвэр амьтан гэдэг ойлголтыг ялган тодорхойлохыг зорьсон.

Мөн “асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан журмын дагуу өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг ойлгохоор тодорхойлсон. Гэрийн тэжээвэр амьтныг өөрийн нэр дээр бүртгүүлээгүй боловч түр хугацаанд хараа хяналтдаа байлгаж байгаа иргэн тодорхой үүрэг, хариуцлага хүлээх шаардлагатай болохыг харгалзан үзэж, гэрийн тэжээвэр амьтныг өөрийн хараа хяналтад байлгаж буй асран хамгаалагчаас бусад иргэнийг “түр харагч” гэсэн нэр томъёогоор хуулийн төсөлд тусгасан.

**Хоёрдугаар бүлэгт** асран хамгаалагч, түр харагчийн эрх, үүргийг тусгасан. Ингэхдээ гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч нь 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, гэрийн тэжээвэр амьтныг хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах орлогын эх үүсвэртэй байх, мөн нохой, муурын асран хамгаалагч нь асран хамгаалагчийн сургалтад хамрагдсан байх нэмэлт шаардлагыг тусгасан.

Хуулийн төслийн зорилгод нийцүүлэн асран хамгаалагчийн эрх, үүргийг нарийвчлан тусгасан. Тухайлбал, олон нийтийн газар гэрийн тэжээвэр амьтантай зорчихдоо тухайн амьтны төрөл, биеийн хэмжээнд тохирсон хүзүүвч, хошуувч, цүнх, хөтөлгөө зэрэг зориулалтын хэрэгсэлтэй авч явах, гэрийн тэжээвэр амьтан бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх гэх мэт.

Нохой, муур нь бусад гэрийн тэжээвэр амьтнаас илүү нийгэм, бусдын эрхэд нөлөө үзүүлдэг, асран хамгаалагч, түр харагчаас өндөр хариуцлага шаарддаг тул нохой, муурын асран хамгаалагч, түр харагчийн нэмэлт үүргийг тусгасан. Үүнд, нохой, мууранд бичил чип суулгуулж, бүртгүүлэх, нохой, муурыг урьдчилан сэргийлэх тарилга, туулгад хамруулах, үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэх, олон нийтийн газрыг нохой, муурын ялгадсаар бохирдуулахгүй байх, бохирдуулсан тохиолдолд орчныг цэвэрлэж, ялгадсыг зориулалтын хогийн сав болон цэгт хаях гэх мэт.

**Гуравдугаар бүлэгт** нохой, муурын нэгдсэн бүртгэлийн талаар зохицуулсан. Гэрийн тэжээвэр амьтдаас хамгийн түгээмэл гудамжинд хаягдаж, “золбин” гэх тодотголыг авдаг нохой, муурыг асран хамгаалагчийн нэр дээр бүртгэдэггүйгээс нохой, муурыг эд зүйл мэт худалдан авч, тэжээхдээ хариуцлагагүй хандаж, гудамжинд хаях зэрэг үйлдэлд хариуцлага тооцох эзэнгүй болдог. Нохой, муурыг асран хамгаалагчийн нэр дээр бүртгэдэг болсноор асран хамгаалагчдын хариуцлага нэмэгдэх, нохой, муурыг тэжээхдээ хариуцлагагүй хандсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжтой болох, улс болон орон нутгийн хэмжээнд байгаа нохой, муурын тоо толгойг гаргах зэрэг эерэг үр дагавар бий болох боломжтой.

Асран хамгаалагч, нохой, муур үржүүлэгч нохой, муурыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид бичил чип суулгуулж, харьяа сум, баг, хорооны Засаг

даргад бүртгүүлнэ. Нохой, муурын бүртгэлийн системийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөгжүүлж, хөтлөхөөр хуулийн төсөлд тусгасан.

**Дөрөвдүгээр бүлэгт** эзэнгүй амьтантай холбоотой харилцааг зохицуулсан. Ингэхдээ бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан ба эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулахад баримтлах зарчмуудыг тусгайлан заасан. Улмаар бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг энэхүү хуульд заасан зарчимд нийцүүлэн зохион байгуулах үүрэг хүлээнэ.

**Тавдугаар бүлэгт** нохой, муур үржүүлэх үйл ажиллагааны талаар зохицуулсан. Нэг хос нохой, муур нь 6 жилийн дараа 67 мянга болж үржих боломжтой гэсэн олон улсын байгууллагын тооцоолол байдаг. Өнгөц харвал нохой, муураа үржүүлэх нь асран хамгаалагчийн эрх мэт харагдаж болох боловч нохой, муурыг нэг удаа үржүүлж, үр төлийг нь гаргах нь эзэнгүй нохой, муурын тоо толгой нэмэгдэхэд хүргэх боломжтой. Үүнийг харгалзан үзэж нохой, муур үржүүлэх гэдэгт нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэх үйл ажиллагааг ойлгохоор зохицуулсан. Улмаар нохой, муурыг нэг удаа үржүүлэхэд энэ хуульд заасны дагуу үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхэлнэ. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгохоор хуулийн төсөлд заасан.

**Зургадугаар бүлэгт** эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааны талаар зохицуулсан. Олон улсад “shelter” нэрээр эзэнгүй амьтныг асран хамгаалагчтай болох хүртэл хугацаанд түр байрлуулан, асрамжлах үйл ажиллагаа явуулдаг улсын болон хувийн байгууллагууд, хувь хүмүүс түгээмэл байдаг. Манай улсад сүүлийн жилүүдэд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдүүд нэмэгдсэн ба албан бус тоогоор 3 төрийн бус байгууллага, 20 орчим хувь хүн байдаг. Зарим хувь хүмүүс түр асрамжлан байрлуулах үйл ажиллагаа эрхэлдэг ч эзэнгүй амьтны нэрийг барин иргэдээс хандив, тусламж авч, түүнийгээ амьдралын эх үүсвэр болгосон байх нь бий. Үүнээс зайлсхийж, түр асрамжлан байрлуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хувь хүн бус ашгийн төлөө бус хуулийн этгээд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр зохицуулсан. Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах гэдэгт арваас дээш нохой, муурыг асран хамгаалагчтай болох хүртэл байрлуулан асрамжлах үйл ажиллагааг ойлгохоор заасан. Уг зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгохоор хуулийн төсөлд тусгасан.

**Долоодугаар бүлэгт** гэрийн тэжээвэр амьтны талаарх төрийн байгууллагын чиг үүргийг тусгасан. Тухайлбал, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь

хяналт тавих, нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нохой, муур үржүүлэх, эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

**Наймдугаар бүлэгт** гэрийн тэжээвэр амьтныг хамгаалах талаар зохицуулсан. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой хүчирхийллийн шинжтэй харгис үйлдэл, эс үйлдэхүй Монгол Улсад түгээмэл гардаг боловч гэрийн тэжээвэр амьтны хүчирхийллийн талаар ойлголтыг тодорхойлж, хариуцлага хүлээлгэх зохицуулалт одоо үйлчилж буй хууль тогтоомжид байхгүй. Хуулийн төсөлд гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэлд тооцогдох 13 төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг тусгасан ба гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйд Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлтэд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгалаа.

**Хуулийн төслийн дагалдуулан боловсруулсан хуулийн төслийн талаар**

Хуулийн төслийг дагалдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг тус тус боловсрууллаа.

### **Иргэдээс ирсэн санал**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах” ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуулийн төслийг [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn) цахим сайтад нийтэлсэн. Ийнхүү олон нийтээс 74<sup>1</sup> хоногийн турш санал авахад давхацсан тоогоор 25872 хүн дэмжиж, давхцаагүй тоогоор 11667 хүн хуулийн төсөлтэй танилцаж, 200 гаруй хүн тусгайлан бичгээр санал өгчээ.

### **ХУУЛЬ САНААЧЛАГЧИД**

---

<sup>1</sup> 2022 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар